

Дундговь аймгийн Засаг даргын Эрчим хүчний сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2022.12.08


Аймгийн Засаг даргын Эрчим хүчний сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын Эрчим хүчний сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 14 үүргийг хүлээж, хэрэгжүүлэн ажилласнаар жилийн эцсийн байдлаар 90 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Нийт 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 8 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээ 90 хувь, 2 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувьтай байна.



ХОЁР.ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ГЭЖ ҮЗЭВ.

Аймгийн төвийн 445 барилга байгууламжийн судалгааг гарган хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар солих ажлыг “Проект ватт” ХХК-тай 4,6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж хүлээн авсан.

Аймгийн төвд шинээр дулааны станц барихтай холбогдуулан Ажлын гүйцэтгэгч “Бьюксан ХХК”, туслан гүйцэтгэгч “Энерго сервис ХХК” 11 дүгээр сарын байдлаар суурин ажил хийгдээд байна.



Байшин барилгын дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Биеийн тамир спортын газрын дээвэрт 150 сая төгрөг, Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн дээврийн засварт 160 сая төгрөг батлан ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдэж хүлээн авсан.

ГУРАВ. ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:


Дулааны 2 хэлхээний шугам сүлжээний зураг төслийн ажлыг эхлүүлж, улсын төсөвт тусгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ


Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Эрчим хүчний салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 90 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 36 хавсралтын дагуу оны эхэнд боловсруулан саналаа хүргүүлэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшинг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга  Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  Д.Одончимэг

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн 

Э.Одончимэг